



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН  
ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Ажлын хариуцлагыг сайжруулах тухай

“Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор төв болон орон нутаг дахь нэгжийн албан хаагчдад ДААЛГАХ нь:

1.орон нутагт ажиллахдаа томилолтын зардлыг зориулалтын дагуу зарцуулж тайлагнах, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдад зардал чирэгдэл, санхүүгийн хүндрэл үүсгэхгүй байх;

2.орон нутагт байгууллага төлөөлөн ажиллаж байгаа албан хаагчид /төлөөлөл/ тухайн аймаг, сумын удирдлага болон хууль хяналтын байгууллагатай төлөвлөгөөний дагуу идэвх санаачилгатай ажиллан, хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан батлуулж, үр дүнг тооцон ажиллах;

3.Мэдээллийн технологийн хэлтсийн хэвлэлийн эх бэлтгэгч нь хэвлэгч машинаар зөвхөн ажил хэргийн холбогдолтой албаны материалыг хэвлэж, олшруулах бөгөөд хэвлэж, олшруулах материалын зориулалт, тоо ширхэгийн талаар Захиргаа, удирдлагын газар /Д.Давааням/-т илтгэх хуудсыг танилцуулж зөвшөөрөл авах;

4.ажлын байранд албан хаагчид төрсөн өдөр, бусад тэмдэглэлт баяр ёслолыг тэмдэглэхгүй байх;

5.албан хаагчид утаат тамхийг байгууллагын хашаан дотор болон зөвшөөрөгдсөн цэгээс өөр газарт татахгүй байх;

6.ажлын цагаар дүрэмт хувцсыг журмын дагуу өмсөх;

7.төвийн ажилтан, албан хаагчид 7 хоногийн Мягмар, Пүрэв гарагт байгууллагын спорт зааланд 17:00-19:00 цагийн хооронд биеийн тамир, спортоор хичээллэж байх;

Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Д.Давааням/-т, биелэлтийг улирал тутам гаргаж танилцуулахыг төв болон орон нутаг дахь нэгжийн дарга нарт даалгасугай.

ДАРГА



Д.МӨРӨН

000000023